



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 01 сарын 13 өдөр

Дугаар А/04

Мандалговь

“Цагдаагийн газрын албан хэрэгцээнд
автомашин” нийлүүлэгчийг сонгон шалгаруулах
үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар санхүүжих “Цагдаагийн газрын албан хэрэгцээнд автомашин” нийлүүлэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: Т.Уранбайгаль (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн)

Гишүүд: Ц.Бямбацогт (Иргэний төлөөлөл)
Ё.Дашням (ИТХ-ын төлөөлөгч)
С.Адъяасүрэн (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга: М.Бат-Эрдэнэ (Орон нутгийн өмчийн газрын Худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн)

Хоёр. Үнэлгээний хороо байгуулагдсанаас хойш ажлын 2 хоногийн дотор хуралдуулж тендер шалгаруулалтыг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулахыг үнэлгээний хорооны дарга (Т.Уранбайгаль)-д даалгасугай.

Гурав. Тендер шалгаруулалттай холбогдолтой бүх баримт бичгээр архивын нэгж бүрдүүлж, холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгөхийг үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (М.Бат-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.ЭРДЭНЭСҮРЭН

482060028